

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн Германы хамтын ажиллагааны сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/272/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудитын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АГУУЛГА

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	7
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	8
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Материаллаг байдал	8
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	8
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
4.5.1 Завсрын аудитын талаар.....	9
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
5. Аудитын илрүүлэлт.....	9
5.1 Төлбөрийн акт	9
Төлбөрийн акт тогтоогоогүй болно.	9
5.2 Албан шаардлага.....	9
Албан шаардлага өгөөгүй болно.....	9
5.3 Зөвлөмж	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/150
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН ГЕРМАНЫ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНГИЙН
ДАРГА Д.ИДЭРМӨНХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн Германы хамтын ажиллагааны сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн Германы хамтын ажиллагааны сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Бранденбург мужийн Барут/Марк хот, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааны хүрээнд "Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежмент" төсөл 2021-2023 онуудад хэрэгжих ба 2022 онд Германы талаас 40,000 евро буюу 129,9 сая төгрөг, Мөрөн сумын Засаг даргын тамгын газраас 13,802 евро буюу 46,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Аудитын гол асуудал

Хогийн савны материалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авалт хийсэн ба энэ тендер "Баян шувуут" ХХК гүйцэтгэгчээр шалгарч тендерийн чанарын баталгаа 7,062.8 мянган төгрөгийг гэрээний дагуу дансанд төвлөрүүлсэн ба санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Засаг даргын тамгын газар, ХБНГУ-ын Барут/Марк хотууд хамтран "Хог хаягдлын менежментийг сайжруулах, дахин боловсруулагдах түүхий эдийг цуглуулах, хог хаягдлаас зайлсхийх" ажлын хүрээнд хамран ажиллах гэрээ байгуулан ажилласан ба гэрээний хэрэгжилтийг хангалттай гэж үнэлсэн байна. 2022 онд тус сангийн үйл ажиллагаанд Ихэр мөрөн аудит ХХК гүйцэтгэлийн аудит хийсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	233,965,026	154,690
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	233,965,026	154,690
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	-
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	233,965,026	154,690
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	7,062,836
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	-	7,062,836
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) төрийн	-	-
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	233,965,026.0	-6,908,146
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	233,965,026	-6,908,146
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	233,965,026	154,690

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31
3	Нийт ашиг (алдагдал)	-
4	Түрээсийн орлого	-
5	Хүүний орлого	-
6	Ногдол ашгийн орлого	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-
8	Бусад орлого	200,219,500.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	441,092,671.55
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-240,873,171.55
19	Орлогын татварын зардал	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-240,873,171.55
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-240,873,171.55
23	Бусад дэлгэрэнгүй орлого	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	
	Бусад олз (гарз)	
24	Орлогын нийт дүн	
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
№	ҮЗҮҮЛЭЛТ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20.. оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	0	0	233,965,026.0	233,965,026
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	-		233,965,026.0	233,965,026
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-240,873,171.6	- 240,873,172
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	20.. оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			- 6,908,145.55	- 6,908,146

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)		
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	275,243,850.65
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	275,243,850.65
1.1.6	Бусад мөнгөн орлого	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	509,054,186.20
1.2.5	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	3,308,839.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	505,745,347.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(233,810,335.55)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
4	Валютин ханшийн зөрүү	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(233,810,335.55)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	233,965,026.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154,690.45

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мөрөн хотын дэд бүтэц, хот төлөвлөлт, хот суурин газрын цэвэр, бохир усны менежмент болон, Мөрөн хотын хог хаягдлын менежментийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Байгаль хамгаалал, байгальд ээлтэй барилга, байгууламжийг барихад нь зөвлөгөө өгөх, сургалтуудыг зохион байгуулах, Иргэдийн эрүүл мэнд, боловсролыг дэмжих, Жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Хөвсгөл аймаг хэрэгжиж байгаа "Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежментийг сайжруулах төсөл" 2022 онд Хог хаягдлын хэмжээг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмрээ оруулах, Ялган ангилагдсан түүхий эдээр дамжуулан орон нутгийн эдийн засгийн эргэлтийг дэмжих, Байгалийн нөөцийг дахин ашиглах, Дахин боловсруулагдах хоёрдогч түүхий эдийн ангилалт, цуглуулалт, тээвэрлэлтийг дэмжих.

2020 онд Мөрөн сумын Засаг даргын тамгын газар, ХБНГУ-ын Барут/Марк хотууд хамтран хийсэн "Тогтвортой хөгжилтэй Мөрөнгийн төлөө хамтдаа" уулзалт зөвлөгөөнөөс "Хог хаягдлын менежментийг сайжруулах, дахин боловсруулагдах түүхий эдийг цуглуулах, хог хаягдлаас зайлсхийх арга хэмжээнүүдийг нэн яаралтай хийж эхлүүлэх ёстой ажлуудын нэг" гэж тодорхойлсны үндсэн дээр энэхүү төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж эхэлсэн байна.

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн Герман хамтын ажиллагааны газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн Герман хамтын ажиллагааны газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах	233,965.0	154.7	(233,810.3)
Нийт хөрөнгө	233,965.0	154.7	(233,810.3)
Дансны өглөг	-	7,062.8	7,062.8

Дансны өглөг 7,062.8 мянган төгрөгөөр өссөн нь Политехник коллежийн гагнуурын ангийн багш суралцагч нар 36 ширхэг ангилан ялгах хогийн сав хийсэн. Энэ хогийн савны материалыг нээлттэй тендер шалгаруулалт зарлаж худалдан авалт хийж, Баян шувуут ХХК төмөр нийлүүлсэн. Энэ тендерийн чанарын баталгаа 7062,8 мянган төгрөгийг гэрээний дагуу дансанд авч үлдэн энэхүү өглөг үүссэн. Үүнийг 2023 онд олгох ёстой.

Хуримтлагдсан үр дүн 233,810.3 мянган төгрөгөөр буурсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн Германы хамтын ажиллагааны сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 1.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл байршуулдаггүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн Герман хамтын ажиллагааны төсөлд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын шалгалтаар төлбөрийн акт тавигдаж бүрэн төлөгдсөн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	652.5	2	652.5	100
Нийт дүн	2	652.5	2	652.5	100

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мөрөн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/224 тоот захирамжаар 30 сургагч багшид олгосон 19,297.3 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй урьдчилгаа олгосон байгаа тул 2023 онд олгох сүүлийн цалингаас суутган тооцсон эсэхэд анхаарал хандуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД